Бичсэн Administrator
2011 оны 8-р сарын 31, Лхагва гариг, 19:14 -

ТОСОЛ

Засгийн газрын 2011 оны …  дугаар тогтоолын хавсралт

**Улсын бvртгэлийн байгууллагын дvрэм**
2011 оны __ сарын __ одор
Улаанбаатар
хот

**Нэг.Нийтлэг vндэслэл**

1.1.Улсын бvртгэлийн байгууллагын эрхэм зорилго нь иргэнд суурилсан торийн бvртгэлийн vнэн бодитой ой санамжийг бий болгох, тор иргэнийг холбосон бvртгэлийн нэгдсэн тогтолцоог бvрдvvлж, торийн бvртгэлийн vйлчилгээгээр иргэний эрхийг хангахад оршино.

1.2. Энэхvv дvрмээр Улсын бvртгэлийн байгууллагын эрх vvрэг, зохион байгуулалтын бvтэцтэй холбогдсон харилцааг зохицуулна.

1.3.Улсын бvртгэлийн байгууллага нь улсын бvртгэлийн хууль тогтоомж болон энэхvv дvрмийг мордож ажиллана.

**Хоёр.Улсын бvртгэлийн ерөнхий газрын бvтэц, удирдлага**

2.1.Еронхий газрын зохион байгуулалтын бүтцийг улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн, орон нутгийн бүртгэлийн байгууллагын бүтэц, орон тоо, ажиллах журмыг Улсын бүртгэлийн еронхий газрын дарга тус тус батална.

2.2.Улсын бүртгэлийн байгууллага нь нийслэлд газар, аймаг, дүүрэгт хэлтсийн зохион байгуулалттайгаар, сум, хороонд улсын бүртгэгч ажиллана.

2.3.Улсын бүртгэлийн еронхий газар нь улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний, нийслэлийн бүртгэлийн газар, аймгийн улсын бүртгэлийн хэлтэс нь Улсын бүртгэлийн еронхий газрын, дүүргийн улсын бүртгэлийн хэлтэс нь нийслэлийн бүртгэлийн газрын, сум, хорооны улсын бүртгэгч нь аймаг, дүүргийн улсын бүртгэлийн хэлтсийн удирдлага дор тус тус ажиллана.

2.4.Улсын бүртгэлийн еронхий газрын даргын дэргэд “Зөвлөл” ажиллана. Зөвлөлийн бүрэлдэхүүн, ажиллах журмыг Улсын бүртгэлийн еронхий газрын дарга батална.

**Гурав. Улсын бүртгэлийн ерөнхий газрын удирдлагын бүрэн эрх**

3.1. Улсын бүртгэлийн еронхий газрын дарга Улсын бүртгэлийн еронхий хуулийн 9 дүгээр зүйлд заасан бүрэн эрхээс гадна дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

3.1.1.Тосвийн байгууллагын удирдлага санхүүжилтийн тухай хуульд заасны дагуу улсын бүртгэлийн еронхий газрын удирдах албан тушаалтантай үр дүнгийн гэрээ байгуулж, биелэлтийг нь дүгнэж, үнэлэлт огч ажиллах;

3.1.2.Улсын бүртгэлийн еронхий газрын орон нутаг дахь бүртгэлийн байгууллагын

хяналтын улсын байцаагч, улсын бvртгэгч, мэргэжилтэнг (захиргааны албан тушаал) газар, хэлтсийн даргын саналыг харгалзан томилж чөлөөлөх;

3.1.3.улсын бvртгэлийн vйл ажиллагааны тайлан мэдээг улсын хэмжээнд нэгтгэн гаргаж, хууль тогтоомжийн дагуу мэдээлэх;

3.1.4.улсын бvртгэлийн хяналтын улсын байцаагчийн акт, дvгнэлт болон бусад шийдвэрийн талаар гарсан гомдол, хууль зөрчсөн vйлдлийн талаархи мэдээллийг хvлээн авах, хянан шийдвэрлэх ажлыг хууль тогтоомжийн хvрээнд зохион байгуулах;

3.1.5.улсын бvртгэлийн vйл ажиллагаанд хэрэглэх тэмдэг, маягтын загварыг батлах.

3.2. Улсын бvртгэлийн ерөнхий газрын даргын эзгvйд тvvний албан vvргийг  захиргааны асуудал хариуцсан орлогч дарга, захиргааны асуудал хариуцсан орлогч даргын эзгvйд бvртгэлийн хяналтын асуудал хариуцсан орлогч дарга тvр орлон гvйцэтгэнэ.

**Дөрөв. Аймаг, нийслэл, дvvргийн улсын бvртгэлийн газар, хэлтэс, тасгийн чиг vvрэг, тvvний удирдлагын бvрэн эрх**

4.1. Аймаг, нийслэл, дvvргийн улсын бvртгэлийн газар, хэлтэс, тасаг нь харьяалах нутаг дэвсгэрийн хэмжээнд дараах чиг vvргийг хэрэгжvvлнэ:

4.1.1. улсын бvртгэлийн хууль тогтоомжийн хvрээнд бvртгэлийн vйл ажиллагааг боловсронгуй болгох арга хэмжээ авах;

4.1.2. улсын бvртгэлийн нэгж болон хяналтын улсын байцаагч, улсын бvртгэгчийн

гаргасан шийдвэртэй холбоотой гомдлыг хянан шийдвэрлэх;

4.1.3. аймаг, нийслэл, сум дvvргийн иргэдийн Толоологчдийн хурал, засаг, захиргааны байгууллага, хууль хяналтын болон бусад байгууллагатай ажлаа уялдуулан зохицуулж, тэдгээрийн дэмжлэг, туслалцааг авах, хамтарч ажиллах ажлыг зохион байгуулах;

4.1.4. улсын бvртгэгчийн тэмдэг болон одор тутмын vйл ажиллагаандаа ашиглаж байгаа vнэт цаас, маягт, зэрэг баримт бичгийн зарцуулалт, хадгалалт, хамгаалалтад хяналт тавих ажлыг зохион байгуулах;

4.2. Орон нутаг дахь улсын бvртгэлийн байгууллагыг Улсын бvртгэлийн еронхий газрын даргын томилсон дарга /цаашид “Нэгжийн дарга” гэх/ удирдана.

4.3. Нэгжийн дарга нь ажлаа Улсын бvртгэлийн еронхий газрын даргын омно хариуцна.

4.4. Нэгжийн дарга нь дараах эрх, vvргийг хэрэгжvvлнэ:

4.4.1.улсын бvртгэлийн хууль тогтоомжийг хэрэгжvvлэх ажлыг орон нутагт зохион байгуулж, бvртгэлийн vйл ажиллагааг боловсронгуй болгох талаар санал боловсруулж, дээд шатны байгууллагад хvргvvлэх;

4.4.2.улсын бvртгэлийн эх нотлох баримтын архив болон цахим мэдээллийн санг vvсгэх, хотлох, торолжvvлэн хадгалах, хадгалалт, хамгаалалтын найдвартай байдлыг хангах;

4.4.3.дээд шатны байгууллага, орон нутгийн торийн захиргааны байгууллага тэдгээрийн харьяа байгууллагын vйл ажиллагаанд дэмжлэг vзvvлж, шаардлагатай мэдээллийг гаргаж огох;

4.4.4.улсын бvртгэгчийн vйл ажиллагааг мэргэжил, арга зvйн удирдлагаар хангаж, vйл ажиллагаанд нь хяналт тавьж ажиллах;

4.4.5.ажилтнуудын мэргэшлийн тvвшинг vнэлж дvгнэх, мэргэшлийн зэрэг олгох болон ажилтнуудын нийгмийн асуудлыг шийдвэрлэхэд дэмжлэг vзvvлэх, шагнуулах, сахилгын шийтгэл ногдуулах санал оруулах;

4.4.6.бvртгэлийн байгууллагын “Ходолморийн дотоод журам”-ыг хууль тогтоомжид нийцvvлэн батлан мордvvлэх, биелэлтэд хяналт тавьж ажиллах, энэхvv дvрэм, холбогдох бусад дvрэм, журмаар олгогдсон эрхийн хvрээнд тушаал шийдвэр гаргах;

4.4.7.бvртгэлийн байгууллагад дэмжлэг vзvvлэх чиг vvрэг бvхий vйлчилгээний албан тушаалтаныг томилж чолоолох;

4.4.8.улсын бvртгэлийн vйл ажиллагааны тайлан мэдээг нэгжийн хэмжээнд нэгтгэн гаргах, хууль тогтоомжийн дагуу мэдээлэх;

4.4.9.байгууллагын стандартыг чанд мордvvлж хэвшvvлэх, иргэн, байгууллагад бvртгэлийн vйл ажиллагааг сурталчлах;

4.4.10.батлагдсан тосвийн хvрээнд монгон хоронгийг зарцуулж, санхvv бvртгэлийн vйл ажиллагаанд дотоодын хяналт тавьж, холбогдох арга хэмжээ авч ажиллах;

4.4.11.санхvv бvртгэлийн хууль тогтоомж, стандарт, дvрэм, журам, зааварт нийцvvлэн нягтлан бодох бvртгэл хотолж, санхvvгийн тайланг гарган тогтоосон хугацаанд холбогдох байгууллагуудад хvргvvлэх, омч хоронгийн хадгалалт, хамгаалалт, ашиглалтад хяналт тавих;

4.4.12.бvртгэлийн vйл ажиллагаатай холбоотой болон албан хаагчдын ёс зvй, зан харьцааны талаар иргэн, байгууллагаас ирvvлсэн оргодол, гомдлыг зохих журмын дагуу

хянан шийдвэрлэх;

4.4.13.Хууль тогтоомжоор олгосон бусад эрх, vvрэг.

4.5.Нэгжийн даргыг тvр  эзгvйд тvvний бvрэн эрхийг улсын ахлах бvртгэгч хэрэгжvvлнэ.

**Тав. Улсын бvртгэгчийн эрх, vvрэг**

5.1. Улсын бvртгэгч нь Улсын бvртгэлийн еронхий хуулийн 11.5 дахь хэсэгт зааснаас гадна дараах эрх, vvрэгтэй байна:

5.1.1.улсын бvртгэлд бvртгvvлэх эрх бvхий болон итгэмжлэгдсэн этгээдээс бус оор этгээдээс оргодол, мэдvvлгийг хvлээн авч улсын бvртгэлд бvртгэхгvй байх;
5.1.2.мэдvvлэг гаргагч мэдvvлгийг vнэн зов, зааврын дагуу боглосон эсэхийг шалгах;

5.1.3.нотлох баримтын бvрдлийг шалган, улсын бvртгэлийг vнэн зов гvйцэтгэх;

5.1.4.тэмдэгтийн хураамж, vйлчилгээний холсийг зохих журмын дагуу бvрэн гvйцэд толvvлэх;

5.1.5.мэдvvлэгт хавсаргасан баримт бичгийг хvлээн авсан огнооны дараалллаар дугаарлаж, хувийн хэрэгт бичилт хийж, зохих журмын дагуу хотлох;

5.1.6. улсын бvртгэлтэй холбоотой маргаан хууль хяналтын байгууллагаар шалгагдаж

байгаа тохиолдолд улсын бvртгэлийг хийхгvй байх;

5.1.7.хууль тогтоомжид зааснаас оор нотлох баримт шаардахгvй байх;

5.1.8.хууль тогтоомжид заасан бусад эрх, vvрэг.